



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/445

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан хотод Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагддаг хөл бөмбөгийн “21 аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2023” тэмцээнд оролцох баг тамирчдын унаа, хувцас хэрэгслийн зардлыг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах нийт 3,796,000 төгрөг (Гурван сая долоон зуун ерэн зургаан мянга)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 7.3 дахь заалт “Спортын аварга” хөтөлбөр төслөөс санхүүжүүлэхийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэндэмбэрэл) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 1065
Zah A/445 Ba

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 10-ны өдрийн
А/445 дугаар захирамжийн хавсралт



ХӨЛ БӨМБӨГИЙН “21 АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭН 2023” ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН
УНАА, ХУВЦАС ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Чиглэл	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
1	Ховд-Улаанбаатар-Ховд	11	2	112,000	2,464,000
2	Улаанбаатар-Дархан-Улаанбаатар	16	2	13,500	432,000
3	Хувцас	15	-	60,000	90,000
	Дүн				3,796,000

-оОо-